

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ

## хөдөлмөр эрхлэлтийн талаарх тоон шинжилгээ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ  
ТООН ШИНЖИЛГЭЭ**

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,  
Хүн амын хөгжлийн бодлогын судалгааны сектор

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

Б.Батбаатар	ХНХСИ-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
М.Алтансүх	ХНХСИ-ийн дэд захирал
С.Чулуунцэцэг	Тамгын газрын дарга
Т.Золзаяа	ХАХБСС-ын эрхлэгч
Б.Төмөрчулуун	НХБСС-ын эрхлэгч
М.Уянга	ХАХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
С.Цэрэндулам	ХАХБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо  
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар  
Утас: 77111331  
Website: [www.rilsp.gov.mn](http://www.rilsp.gov.mn)

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....	iii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	iv
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	v
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	VI
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ .....	VII
ХУРААНГУЙ.....	IX
<b>I БҮЛЭГ. АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....</b>	<b>1</b>
1.1. Танилцуулга .....	1
1.2. Арга зүй.....	2
1.3. Хамрах хүрээ .....	2
<b>II БҮЛЭГ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ .....</b>	<b>5</b>
2.1. Аж ахуйн нэгж, байгууллагуудын өнөөгийн байдал.....	5
2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй ажил олгогч .....	11
2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах орон тоонд төлбөр төлж буй ажил олгогч.....	17
2.4. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийг хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагууд .....	22
<b>III БҮЛЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА АЖИЛГҮЙДЭЛ .....</b>	<b>25</b>
3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээллийн өнөөгийн байдал.....	25
3.2. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд .....	26
3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилгүйдэл .....	29
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>31</b>
<b>САНАЛ ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>33</b>

## ӨМНӨХ ҮГ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх эрхийг хангах, чадавх чадамжаа хөгжүүлэн, амьдралын чанараа дээшлүүлэх, тэгш боломж олгохуйц нийгмийн ээлтэй орчныг бүрдүүлэхэд дэлхий нийт онцгой анхаарч байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн талаарх тоон шинжилгээг “Монгол улсын хөдөлмөрийн тухай” хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг судлах, санал зөвлөмж боловсруулах зорилгоор хийж гүйцэтгэлээ.

Шинжилгээний ажилд 2018 онд хийгдсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-д үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулж байгаа эсхүл төлбөр төлж буй аж ахуй нэгж, байгууллагууд, ажил идэвхтэй хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо мэдээллийг шинэчилж, харьцуулан, захиргааны мэдээнд дүн шинжилгээ хийж тайлагнасан.

Та бүхэн шинжилгээний ажилтай танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлалтай холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БАТБААТАР

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Захиргааны тоон мэдээллийн төрөл.....	3
Хүснэгт 2. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажилтантай нийт ААНБ, эдийн засгийн салбарын ангиллаар .....	9
Хүснэгт 3. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын хэрэгжилтийн байдал.....	10
Хүснэгт 4. ХБИ-ийг ажиллуулбал зохих орон тоонд ажиллуулсан тоо, аймгаар .....	13
Хүснэгт 5. 25, түүнээс дээш ажилтантай хуулийн этгээдийн суутгуулагчийн мэдээлэл ...	15
Хүснэгт 6. Сар бүр төлөх төлбөрийн хэмжээг тооцох тухай 2019 он .....	17
Хүснэгт 7. Сар бүр төлөх төлбөрийн хэмжээ 2019 оноос өмнө.....	18
Хүснэгт 8. ХЭДС-д төлбөр төлсөн ААНБ-ын тоо, төвлөрсөн хөрөнгө, өмчийн хэлбэр, байршлаар .....	18
Хүснэгт 9. Дэмжих санд төлбөр төлөх, төлбөр төлсөн ААНБ-тоо.....	20
Хүснэгт 10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насны бүлэг, хүйсээр 2019 он .....	26
Хүснэгт 11. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байршлаар.....	28
Хүснэгт 12. Ажил хайж буй шалтгаан .....	30

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, улирал, ажиллагчдын тооны бүлгээр, мянгаар .....	5
Зураг 2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 20 ба түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын өмчийн хэлбэр, улирлаар .....	6
Зураг 3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай нийт ААНБ-ын өмчийн хэлбэр .....	7
Зураг 4. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажилтантай нийт ААНБ, байршлаар, 2019 он .....	7
Зураг 5. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 25, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын тоо, өмчийн хэлбэр, аймаг, дүүргээр 2019 он .....	8
Зураг 6. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын хэрэгжилтийн байдал, байршлаар, 2019 он .....	10
Зураг 7. ХБИ-ийг ажиллуулж буй ААНБ-ын тоо, 2019 он .....	11
Зураг 8. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын хэрэгжилт, салбараар, 2019 он .....	11
Зураг 9. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын хэрэгжилт, аймгаар, 2019 он ...	12
Зураг 10. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын хэрэгжилт, дүүргээр, 2019 он	14
Зураг 11. ХБИ-ийг ажиллуулбал зохих орон тоонд ажиллуулсан хувь, дүүргээр .....	14
Зураг 12. ААНОАТ-ын тухай хуульд орсон өөрчлөлт .....	16
Зураг 13. Албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан ААНБ-ууд .....	17
Зураг 14. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулаагүй орон тоонд төлбөр төлсөн аймаг .....	19
Зураг 15. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулаагүй орон тоонд төлбөр төлсөн дүүрэг .....	20
Зураг 16. ХЭДС-д төлбөр төлөгч ААНБ-ууд, эдийн засгийн салбарын ангиллаар, хувиар .....	21
Зураг 17. Судалгаанд хамрагдсан ААНБ-ууд, төлбөр төлж буй хугацаа, хувиар .....	22
Зураг 18. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй ААНБ-уудын эзлэх хувь .....	22
Зураг 19. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй ААНБ-ууд, салбараар .....	23
Зураг 20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй ААНБ-ууд, аймгаар .....	23
Зураг 21. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй ААНБ-ууд, дүүргээр .....	24
Зураг 22. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бэрхшээлийн хэлбэрээр 2019 он .....	26
Зураг 23. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, 2016 – 2019 он ...	27
Зураг 24. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нас, хүйсийн суварга, 2019 он .....	27
Зураг 25. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил мэргэжлийн ангиллаар .....	28
Зураг 26. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд, салбараар .....	29
Зураг 27. Ажил хайгчаар бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын түвшин .....	29

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ЗГ	Засгийн газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МУ	Монгол Улс
МШӨ	Мэргэжлээс шалтгаалсан өвчин
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Татварын ерөнхий газар
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЭХМК	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс



## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хөгжлийн бэрхшээл, түүний хэлбэрүүд	
<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүн</b>	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна. <i>Эх сурвалж: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 4.1.1</i>
<b>Төрөлхийн</b>	Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.
<b>Олдмол</b>	Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.
<b>Харааны</b>	Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.
<b>Ярианы</b>	Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.
<b>Сонсголын</b>	Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна.
<b>Хөдөлгөөний</b>	Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг хамруулна.
<b>Сэтгэцийн</b>	Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан хүнийг хамруулна.
<b>Хавсарсан</b>	Нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд хамруулна. (Тухайлбал: сэтгэцийн, хөдөлгөөний бэрхшээлтэй байж болно гэх мэт.)
<b>Бусад</b>	Ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан хүнийг хамруулна. (Тухайлбал: дотор эрхтний эмгэгүүд, хавдар гэх мэт)
Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл	
<b>Ажиллах хүч</b>	Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм. <i>Эх сурвалж: ҮСХ, Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлал</i>

<b>Ажиллах хүчнээс гадуурх хүн ам</b>	Сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчин(тодорхойлолт 2.16.3)-ийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ <i>Эх сурвалж: ҮСХ, Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүдийг тооцох</i>
<b>Аж ахуйн нэгж</b>	Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг хэлнэ.
<b>Ажил олгогч</b>	Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа этгээдийг хэлнэ.
<b>Ажиллагч</b>	Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.
<b>Ажилгүйдэл</b>	Хөдөлмөрийн чадвартай хүн ажил хөдөлмөр эрхлэхийг хүсч, түүнийг идэвхтэй эрж байгаа ч ажил олдохгүй байдал.
<b>Ажилгүй иргэн</b>	“Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу “Ажилгүй иргэн” гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.
<b>Ажил хайгч</b>	Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн болон хандсан иргэнийг хэлнэ.
<b>Бусад</b>	
<b>Суутган төлөгч</b>	Тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг хэлнэ. <i>Эх сурвалж: Татварын ерөнхий хууль 6.1.19</i>
<b>Татвар төлөгч</b>	Татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэг бүхий этгээд, эсхүл суутган төлөгчийг хэлнэ. <i>Эх сурвалж: Татварын ерөнхий хууль 6.1.20</i>
<b>Тахир дутуугийн тэтгэвэр</b>	Ажил хөдөлмөр эрхлэн шимтгэл төлж, ажиллаж байгаад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч иргэн өнгөрсөн хөдөлмөрийн үйл ажиллагаанаас хамааралтайгаар авч байсан цалин, хөдөлмөрийн хөлснөөс тооцож зориулалтын сангаас түүний хөдөлмөрийн чадваргүй байгаа хугацаанд буюу хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр олгож байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.
<b>Эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа</b>	Хүмүүсийн оюун ухаан, мэдрэхүй, бие бялдрын хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж тахир дутуу /хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас /хэсэгчлэн/ алдсан/ болсон шалтгаан, түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох мэргэжлийн үйл ажиллагааг эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа гэнэ. <i>Эх сурвалж: Нийгмийн даатгалын тухай хууль 28.1 1994/05/31</i>

## ХУРААНГУЙ

Шинжилгээний ажлын зорилго нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон хөгжлийн бэрхшээлтэй иргэний захиргааны тоо мэдээнд шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж боловсруулахад оршино.

Шинжилгээний ажлаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн сангаас Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дугаар заалтыг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны тоон мэдээнд шинжилгээ хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах өнөөгийн боломж, бололцоог тооцоолсон.

ҮСХ-ны Бизнес регистрийн санд 2019 оны байдлаар 187.8 мянган ААНБ бүртгэлтэй байгаагийн 94.4 мянга нь үйл ажиллагаа явуулж байна.

НДЕГ-ын мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажилтантай нийт аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2018 онд 7 202, 2019 онд 7 766 байна. 2019 онд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 25 ба түүнээс дээш ажилтантай нийт аж ахуйн нэгж байгууллагын 3 423 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж байна. Эдгээр ААНБ-ууд Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтыг хэрэгжүүлж буй байдлыг харвал 2018 онд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулбал зохих нийт орон тооны 26.1 хувьд, 2019 онд 26.4 хувьд ажиллуулж байна. Хэрэв 25 ба түүнээс дээш ажилтантай бүх ААНБ-ууд Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажилласан бол 2018 онд 22 321, 2019 онд 24 322 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлын байртай болох боломжтой байсан хэдий ч хуулийн хэрэгжилт хангагдаагүйгээс эдгээр ажлын байруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй ААНБ-уудын 63.1 хувь нь орон нутагт, 36.9 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

ХБИ-ийг хамгийн ихээр ажиллуулж буй салбарууд нь боловсрол, эрүүл мэнд, төрийн удирдлагын салбарууд байгаа бол хамгийн бага хувиар ажиллуулж буй салбар нь худалдаа, барилга, уул уурхайн салбарууд байна. Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж буй байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулбал зохих нийт орон тооны 46.1 хувьд ажиллуулж байгаа нь орон нутгийн дундажтай харьцуулахад 31.1 пунктээр бага байна.

НДЕГ-ын мэдээгээр 25 ба түүнээс дээш ажилтантай хэдий ч Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй ААНБ-ын тоо 2018 онд 4 096 буюу нийт ААНБ-ын 56.9 хувь, 2019 онд 4 343 буюу 55.9 хувийг эзэлж байна.

Манай улсад 2019 оны байдлаар 107 639 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь нийт хүн амын 3.2 хувийг эзэлж байна. Тэдний 90.7 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам байна.

НДЕГ-ын мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2018 онд 7 833 мянга байсан бол 2019 онд 9 179 мянга болж өссөн байна.

Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг насны бүлгээр авч үзвэл тэтгэвэрт гарахын өмнө буюу эмэгтэйчүүд 50-54 насанд, эрэгтэйчүүд 55-59 насанд хөдөлмөр эрхлэх нь өндөр байгаа бол 20-24 болон 65-аас дээш насанд хөдөлмөр эрхлэх нь хамгийн бага байна.

Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд ихэвчлэн багш, мэргэжилтэн, эрүүл мэндийн мэргэжилтэн, бизнес захиргааны мэргэжилтэн, менежерээр ажиллах нь түгээмэл байна.

2019 онд хөдөлмөрийн тухай хуулийн 111.2-т заасны дагуу ХБИ-ийг ажиллуулаагүй нийт ААНБ-ын 6.0 хувь нь буюу 259 байгууллага ХЭДС-д төлбөр төлсөн байна. Эдгээр ААНБ-аас хамгийн их нь 12 тооны ХБИ-ийг ажиллуулах орон тоонд төлбөр төлдөг бөгөөд дунджаар нэг ААНБ гурван ХБИ-ийг ажиллуулах орон тоонд төлбөр төлж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111.6-д зааснаар “Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сар ноогдох төлбөрөөс чөлөөлөгддөг. 2017, 2018 онд тасралтгүй төлбөр төлсөн байгууллага цөөн ба 2019 онд огцом буурсан үзүүлэлт биш юм. ААНБ-ууд ХБИ ажиллуулснаар төрөөс авах дэмжлэгийн талаархи хуулийн мэдээлэл дутмаг байх, мөн төлбөрийг дундаж цалинтай уялдуулж төлж байгаа зэрэг олон шалтгааны улмаас төлбөр төлж байгаа ААНБ-уудын тоо маш бага байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тус хуулийн заалтын дагуу 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 969.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн бол 2019 оны 12 дугаар сарын байдлаар 3.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Шинжилгээний ажлыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд үндэслэн хийсэн ба судалгаанд ХЭДС-д төлбөр төлсөн ААНБ-ын тоо, төвлөрсөн хөрөнгийг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дүнгээр харьцуулж тооцсон. Дээрх дүнг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дүнтэй харьцуулбал төлбөр төлсөн ААНБ-ын төвлөрсөн хөрөнгө 3.0 тэрбум болж өссөн нь 2019 оноос өмнө Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймагт 50-аас доош ажиллагчидтай байгууллага хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 40 хувиар, 50-аас дээш ажиллагчидтай байгууллага хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиар, бусад аймагт 30 хувиар төлдөг байсан бол Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй орон тоо тутамд төлөх төлбөрийн хэмжээг дундаж цалинтай уялдуулан тогтоож эхэлсэнтэй холбоотой.

Төлбөр төлсөн ААНБ-ыг байршлаар авч үзвэл аймаг, сумдад 25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага бага байдаг тул төлбөр төлж буй байгууллагуудын 70 орчим хувь нь Улаанбаатар хотод байна. 2018 онд төлбөр төлсөн нийт байгууллагын 85.5 хувийг хувийн хэвшил, 14.5 хувийг төрийн өмчит байгууллагууд эзэлж байсан бол 2019 онд 87.5 хувийг хувийн хэвшил, 12.5 хувийг төрийн өмчит байгууллагууд эзэлж байна.

# БҮЛЭГ I

АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

# I БҮЛЭГ. АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 1.1. Танилцуулга

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг. Түүнчлэн тус конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт, хандлага нийгмийн аль ч түвшинд хангалтгүй, хүний эрхийн хувьд адил тэгш бус, халамж хүртэгч, өвчтөн, нийгмийн идэвхгүй гишүүн мэтээр хандах хандлага байсаар байна. Манай улсад 2019 оны байдлаар 107 639 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь нийт хүн амын 3.2 хувийг эзэлж байна. Тэдний 57.1 хувь нь эрэгтэйчүүд, 42.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дүгээр зүйлд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулна гэж заасан байдаг. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2018 оны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-аар улсын хэмжээнд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага 5 230 байгаагаас 39.4 хувь нь буюу 2 061 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байна. Эдгээрийн 41.9 хувь нь буюу 863 аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасан квотын дагуу, үлдсэн хувь нь хуульд заасан квотоос цөөн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байна.

Тус судалгааны дүнгээс харахад ажил олгогчдод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах сонирхол төдийлөн байдаггүй, тэдгээр иргэдийн ажлын бүтээмж, байгууллагын үйл ажиллагаанд оруулах хувь нэмэрт эргэлздэг зэрэг хандлага нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудалд тусгайлан анхаарал хандуулж олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч 2018 онд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 128 дугаар зарлигийг санаачилж Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй орон тоо тутамд төлөх төлбөрийн хэмжээг дундаж цалинтай уялдуулан төлж байхаар шинэчлэн тогтоосон. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй 25, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ууд Улаанбаатар, Орхон, Дархан-Уул аймагт тухайн байгууллагын ажиллагчдын дундаж цалингийн хэмжээгээр, бусад аймагт дундаж цалингийн 60 хувиар тооцон төлбөр төлж, төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж байна.

Ажлын байрны төлбөр төлүүлэхээс илүүтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангах, тэдний бэрхшээлийн онцлогт тохирсон хүртээмжтэй орчныг бий болгох, ажил олгогч, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулахыг зорих нь чухал юм. Тиймээс бид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой захиргааны тоон мэдээнд дүн шинжилгээ хийх, хуулийн хэрэгжилтийн зохицуулалтад өөрчлөлт орсонтой холбоотойгоор тоон мэдээг өмнөх оны

мөн үеийн хэрэгжилттэй харьцуулах, бодлогын зөвлөмж боловсруулах хэрэгцээ шаардлагын улмаас энэхүү шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

## ЗОРИЛГО

Шинжилгээний ажлын зорилго нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой захиргааны тоо мэдээнд дүн шинжилгээ хийхэд оршино. Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол, тушаал, журмуудын хэрэгжилтийг судлах,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тоон мэдээллүүдийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, өмнөх судалгааны дүнтэй харьцуулах,
- Судалгааны дүгнэлтийг үндэслэн зөвлөмж боловсруулах.

### 1.2. Арга зүй

Шинжилгээний ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг холбогдох байгууллагуудаас цуглуулж нэгтгэсэн. Холбогдох тоон мэдээлэл дээр үндэслэн харьцуулалтын аргыг ашиглан мэдээллийг шинжилж, тайланг боловсруулсан.

### 1.3. Хамрах хүрээ

Тоон шинжилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дараах захиргааны мэдээнд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:



#### ХБИ-ийн мэдээ

- Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- Ажил хайгчаар бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн



#### ААНБ-ын мэдээ

- Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 дэх заалтыг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага
- Хөдөлмөрийн тухай хуулийн 111.2 дахь заалтыг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага
- Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дахь заалтуудыг үл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага

Хүснэгт 1. Захиргааны тоон мэдээллийн төрөл

Д/д	Тоон мэдээллийн төрөл	Үзүүлэлт	Эх сурвалж
1	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа, 25 ба түүнээс дээш ажилтантай нийт аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ	<ul style="list-style-type: none"> <li>- Ажилчдын тооны бүлэг</li> <li>- Өмчийн хэлбэр</li> <li>- Байршил</li> </ul>	Үндэсний статистикийн хороо, бизнес регистрийн сан
2	Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25, түүнээс дээш ажилтантай нийт аж ахуйн нэгж, байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ	<ul style="list-style-type: none"> <li>- Ажилчдын тооны бүлэг</li> <li>- Өмчийн хэлбэр</li> <li>- Эдийн засгийн салбарын ангилал</li> <li>- Байршил</li> </ul>	Нийгмийн даатгалын ерөнхий газар
3	ХЭДС-д төлбөр төлсөн нийт аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ	<ul style="list-style-type: none"> <li>- Ажилчдын тооны бүлэг</li> <li>- Өмчийн хэлбэр</li> <li>- Эдийн засгийн салбарын ангилал</li> <li>- Төлбөр төлсөн орон тоо</li> <li>- Төлбөр төлсөн хугацаа</li> <li>- Байршил</li> </ul>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
4	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ <i>/ААНОАТ-ын хуулийн 18.1.4, 19.8, 19.10 дах заалтуудаар албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн нийт ААНБ/</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Суутган төлөгчийн тоо</li> <li>- Суутгуулагчийн тоо</li> <li>- Хөнгөлөх татварын дүн</li> <li>- Чөлөөлөх татварын дүн</li> </ul>	Татварын ерөнхий газар
5	Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээ <i>/Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч/</i>	<ul style="list-style-type: none"> <li>- Нас, хүйс</li> <li>- Ажил мэргэжлийн ангилал</li> <li>- Эдийн засгийн салбарын ангилал</li> <li>- Байршил</li> </ul>	Нийгмийн даатгалын ерөнхий газар
6	Ажил хайгчаар бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээ	<ul style="list-style-type: none"> <li>- Нас, хүйс</li> <li>- Боловсролын түвшин</li> <li>- Эзэмшсэн мэргэжил</li> <li>- Хайж буй ажлын байр</li> <li>- Ажил хайж буй байршил</li> <li>- Ажил хайж буй шалтгаан</li> </ul>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



# БҮЛЭГ II

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ДАХЬ  
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

## II БҮЛЭГ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ


Тайлангийн энэ бүлэгт ҮСХ-ны Бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ, хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээ<sup>1</sup>, хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй орон тоонд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлбөр төлсөн аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээ<sup>2</sup>, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.1.4, 19.8 дах заалтаар албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээ<sup>3</sup>-нд хийсэн шинжилгээний үр дүнг танилцуулах болно.

### 2.1. Аж ахуйн нэгж, байгууллагуудын өнөөгийн байдал

ҮСХ-ны Бизнес регистрийн санд 2019 оны байдлаар 187.8 мянган ААНБ бүртгэлтэй байгаагийн 94.4 мянга нь үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 67.3 хувь нь Улаанбаатар хотод, 32.7 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ыг ажиллагчдын тооны бүлгээр авч үзвэл 2019 оны байдлаар 81.2 мянга буюу 86.1 хувь нь 9 хүртэлх ажиллагчидтай, 6.3 мянга буюу 6.6 хувь нь 10-19 хүртэлх ажиллагчидтай байгаа бол 6.9 мянга буюу 7.3 хувь нь 20, түүнээс дээш ажиллагчидтай байна.<sup>4</sup>

Зураг 1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, улирал, ажиллагчдын тооны бүлгээр, мянгаар



Эх сурвалж: ҮСХ, Бизнес регистрийн сан

<sup>1</sup>Нийгмийн даатгалын ерөнхий газар


<sup>2</sup>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

<sup>3</sup>Татварын ерөнхий газар

<sup>4</sup>Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалт нь 25, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-д хамааралтай бөгөөд ҮСХ-ний Бизнес регистрийн сангийн ангилал нь 20-49, 50 ба түүнээс дээш ажиллагчидтай гэж гардаг.

Зураг 2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 20 ба түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын өмчийн хэлбэр, улирлаар

Хэмжих нэгж: хувь



Эх сурвалж: ҮСХ, Бизнес регистрийн сан


Үйл ажиллагаа явуулж байгаа 20, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-уудын өмчийн хэлбэрийг сүүлийн 5 жилийн байдлаар харвал 2013 онд төрийн өмчийн байгууллага 47.4 хувийг эзэлж байсан бол 2019 онд 40.2 болж буурсан байна. Харин хувийн өмчийн ААНБ-ууд 2013 онд 46.7 хувийг эзэлж байсан бол 2019 онд 53.1 болж өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2019 оны байдлаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 6.7 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага эзэлж байна.

#### **Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажилтантай нийт аж ахуйн нэгж, байгууллагууд**

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ногдуулах гэх мэт зохицуулалт хийсэн байдаг.

НДЕГ-ын мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажилтантай нийт аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2018 онд 7 202, 2019 онд 7 766 байна. Эдгээр байгууллагуудыг өмчийн хэлбэрээр авч үзвэл ойролцоогоор хоёр байгууллага тутмын нэг нь хувийн өмчийн байгууллага байна.

Зураг 3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажиллагчидтай нийт ААНБ-ын өмчийн хэлбэр



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

2019 оны байдлаар нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажилтантай нийт 7.7 мянга гаруй аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас 59.3 хувь нь Улаанбаатар хотод, 40.7 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 4. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, 25 ба түүнээс дээш ажилтантай нийт ААНБ, байршлаар, 2019 он



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 25, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын дийлэнх нь буюу 69.0 хувь нь төрийн, 22.9 хувь нь хувийн, 8.1 хувь нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд байна. Нийт 25, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын тоогоор Өмнөговь аймаг тэргүүлж, тус ангиллын хувийн хэвшлийн ААНБ-ын тоогоор мөн Өмнөговь аймаг тэргүүлж байна. Харин 25, түүнээс дээш ажиллагчидтай ААНБ-ын тоо хамгийн бага аймаг нь Говьсүмбэр аймаг байна.